



Бурхан бол Хайр Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол Хайр

Attribute: God Is Love

Тодорхойлолт: Хүчирхэг, халуун дотно, энхрий зөөлөн сэтгэлт, хайр энэрлээр дүүрэн Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Дуулал 136:1-9** ЭЗЭНд талархагтун. Тэрээр сайн сайхан бөгөөд, Түүний хайр энэрэл мөнхийнх. Бурхдын Бурханд талархагтун. Түүний хайр энэрэл мөнхийнх. Эздийн Эзэнд талархагтун, Түүний хайр энэрэл мөнхийнх. Агуу гайхамшгуудыг ганцаар үйлдэгч Түүнд талархагтун, Түүний хайр энэрэл мөнхийнх. Мэргэнээр тэнгэрсийг бүтээсэн Түүнд талархагтун. Түүний хайр энэрэл мөнхийнх. Газрыг усан дээгүүр дэлгэсэн Түүнд талархагтун. Түүний хайр энэрэл мөнхийнх. Агуу гэрлүүдийг бүтээсэн Түүнд талархагтун. Түүний хайр энэрэл мөнхийнх. Нараар өдрийг захируулагч Түүнд талархагтун. Түүний хайр энэрэл мөнхийнх. Сар ба оддоор шөнийг захируулагч Түүнд талархагтун. Түүний хайр энэрэл мөнхийнх.
- **Ефес 3:16-19** Тэрээр Өөрийн алдрын баялгийн дагуу, Сүнснийхээ хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ зүрхэнд тань нутаглаж, та нар хайр дотор үндэслэгдэн суурилагдаад, тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг бүх ариун хүний хамт ойлгох болтугай. Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрлээр бялхах болтугай.
- **1 Иохан 3:1** Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулахаар ямар их хайрыг Эцэг бидэнд соёрхсоныг хараач! Бид бол чухам энэ л юм. Биднийг ертөнц таньдаггүй нь Түүнийг таниагүйн учир юм.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Марк 12:30

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр) Бурхан Эзэнээ болох Таныг бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүч чадлаараа хайрлах болтугай.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____ Бурхан Эзэнээ болох Таныг бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүч чадлаараа хайрлах болтугай. *Марк 12:30*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!